

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/18

Сүмбэр сум

Түр хамгаалах байрны нөөц
бүрдүүлэхэд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайдын 2020 оны “Ковид-19 цар тахлын онцгой нөхцөл байдлын үед хүүхэд хамгааллын салбар дундын бүлгийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө”, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны “Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/10 дугаар тушаал, аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний 7 дугаар зүйлийн 7.1, байгууллагын “Гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө”-ний 4.5, 4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Түр хамгаалах байрны хоол хүнс, ахуйн болон ариутгал, халдваргүйжүүлэлтийн материал, түлш шатахууны нөөцийг 30 хүртэлх хоногоор бэлтгэх ажлын удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тус үйл ажиллагааг зохион байгуулж, тайлагнахыг сэтгэл зүйч (Г.Мөнхчимэг)-д үүрэг болгосугай.


3.Тус үйл ажиллагаанд шаардагдах 2.658.500 (хоёр сая зургаан зуун тавин найман мянга таван зуу) төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг нягтлан бодогч (Д.Оюунцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Ц.ОЮУНБИЛЭГ



Д:/Бичиг хэрэг /тушаал

ГБХЗХГазрын даргын 2021 оны
03 сарын 09-ний өдрийн
дугаар тушаалын 1-р хавсралт



**ТҮР ХАМГААЛАН БАЙРЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАЖ,
НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Говьсүмбэр аймаг

2021.03.09

Зорилго: Монгол Улсад коронавирусын халдвар тархсантай холбоотойгоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, шаардлагатай тусламж, зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх, анхан шатны суурь хэрэгцээг хангаж, түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлж ажиллах бэлэн байдлыг хангасан байна.

Хамрах хүрээ: Түр хамгаалах байраар үйлчлүүлэгчид


Зохион байгуулагч: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

Хугацаа: 2021 оны 03 дугаар сарын 09-ны өдрөөс 2021 оны 4 дүгээр сарын 09-ны өдөр

Үр дүн: Онцгой нөхцөл байдлын үед гэр бүлийн болон бусад орчинд хүүхдийн эрх зөрчигдсөн, эрсдэлт нөхцөл байдалд орсон, хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд, насанд хүрэгчдэд түр хамгаалан байрлуулах үйлчилгээний үндсэн үйлчилгээнүүд болох анхан шатны суурь хэрэгцээг хангах, боловсрол, эрүүл мэндийн, халамжийн үйлчилгээг түргэн шуурхай, нэг дор үзүүлэх бэлэн байдал хангагдсан байна.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН
ГБХЗХГ-ЫН СЭТГЭЛ ЗҮЙЧ: Г.МӨНХЧИМЭГ

ГБХЗХГазрын даргын 2021 оны
 03 сарын 09-ний өдрийн
 дугаар тушаалын 2-р хавсралт



ТҮР ХАМГААЛАН БАЙРЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАЖ,
 НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ АЖЛЫН ТӨСӨВ

Говьсүмбэр

Бараа материалын нэр	Тоо ширхэг		Нэг бүрийн үнэ	Нийт
Хоол хүнс				
Будаа	20	кг	2500	50.000
Хонины мах	25	кг	11000	275.000
Гурил	25	кг	33600	33.600
Тос	4	ш	3800	15.200
Гоймон	2	ш	8800	17.600
нийт				391.400
Ахуйн бараа				
Угаалгын нунтаг	2	ш	4500	9.000
Ариутгалын бодис /жавелин/	20	ш	300	6.000
Гарын шингэн саван	7	ш	6500	45.500
Барааны саван	10	ш	1000	10.000
Резинен бээлий	10	ш	1300	13.000
Нойлын цаас	12	ш	800	9.600
Аяга угаагч шингэн	2	ш	4500	9.000
Нэг удаагийн улавч	2	боодол	3000	6.000
Хүүхдийн шүдний сойз	10	ш	2000	20.000
Шүдний оо	4	ш	2200	8.800
Шампунь	2	ш	13200	26.400
Гарын хатуу саван	10	ш	2000	20.000
Амны хаалт	100	ш	200	20.000
Хогийн уут	8	ш	2800	22.400
Белизна	4	ш	3900	15.600

117

Хивс угаагч шингэн	8	ш	4100	32.800
Утеноч /нойл угаагч шингэн/	4	ш	6000	24.000
Нойлын агааржуулагч	4	ш	6000	24.000
нийт				322.100
Хүүхдийн хувцас				
Хүүхдийн турсик	10	ш	3500	35.000
Хүүхдийн оймс	10	ш	2500	25.000
Хүүхдийн өмд	10	ш	7000	70.000
Хүүхдийн пудволк	10	ш	7000	70.000
нийт				200.000
Ном				
Дэлхийн хүүхдийн сонгодог уран зохиолын ном	28	ш	15000	420.000
Хүүхдийн уран зохиолын ном	30	ш	15000	450.000
нийт				870.000
Бусад				
Биеийн жин хэмжигч	1	ш	30.000	30.000
Тасалгааны цэцэг	3	ш	50.000	150.000
Үнэртэй лаа	10	ш	8000	80.000
Санитол	10	ш	13000	130000
Бээлий	1	хайрцаг	30000	30000
Маск	150	300	45000	45000
Ариутгал халваргүйжүүлэлт	3	100000	300000	300000
Номын тавиур	1	ш	110000	110000
нийт				875.000
Нийт төсөв:				2.658.500

ТӨСӨВ БОЛОВСРУУЛСАН
ГБХЗХГ-ЫН СЭТГЭЛ ЗҮЙЧ: Г.МӨНХЧИМЭГ

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД,
ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР**

Төслийн нэр: “Хохирогчийг түр хамгаалах байрны үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах”

Төслийн зорилго: Хохирогчийг түр хамгаалах байраар үйлчлүүлэх хүүхэд эмэгтэйчүүд, насанд хүрэгдэд тав тухтай, амар тайван үйлчлүүлэх орчин нөхцлийг бүрдүүлж, тэдэнд үзүүлэх боловсролын, халамжийн, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилготой.

Төслийн байршил: ГСА-ийн Сүмбэр сум, 3-р баг, 1-р байр, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх түр хамгаалах байр

Утас: 70543661, 99941951

Төсөл боловсруулсан: Сэтгэл зүйч

Г.Мөнхчимэг

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн нэр: “Хохирогчийг түр хамгаалах байрны үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах”

1.2 Төслийн байршил: Говьсүмбэр аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх түр хамгаалах байр

1.3 Төслийн хэрэгжүүлэгч: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын сэтгэл зүйч Г.Мөнхчимэг

1.4 Төслийг хэрэгжүүлэх хугацаа: 2021 оны 2-3 сард

1.5 Төслийн нийт төсөв: 3.482.990

1.6 Төслийн зорилго: Хохирогчийг түр хамгаалах байраар үйлчлүүлэх хүүхэд эмэгтэйчүүд, насанд хүрэгчдэд тав тухтай, амар тайван үйлчлүүлэх орчин нөхцлийг бүрдүүлж, тэдэнд үзүүлэх боловсролын, халамжийн, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилготой.

Зорилт:

- Түр хамгаалах байраар үйлчлүүлэх үйлчлүүлэгч нарт ая тухтай орчин нөхцөл бүрдүүлэх
- Хүүхэд багачуудыг боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах
- Дулаан хувцас хэрэгслээр хангах
- Үйлчлүүлэгчийн аюулгүй тайван байдлыг хангах

1.7 Хүрэх үр дүн: Энэхүү төсөл хэрэгжсэнээр түр хамгаалах байраар үйлчлүүлэх үйлчлүүлэгч нар өөрт шаардлагатай үйлчилгээг бүрэн авч, болзошгүй өвчлөл, осол гэмтэл, аюулаас урьдчилан сэргийлэгдэх юм.

1.8 Төслийн үндэслэл:

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/116 дугаар тушаалаар батлагдсан “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх” журмын дагуу ажиллаж байна.

Энэхүү журманд 1.1 Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор тэдний аюулгүйн зэргийн үнэлгээ болон нөхцөл байдалын үнэлгээг үндэслэн тусгай байранд түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх

3.Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим

3.1. Аюулгүй байдлыг тэргүүн ээлжинд хангана: Түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлэхдээ хохирогчийн аюулгүй байдлыг тэргүүн зэрэгт тавина.

3.2. Нууцлалыг чандлан хадгалана: Түр хамгаалах байрны байршилийг нууцална. Хохирогчийн нэр төр, үнэ цэнэ, өөртөө итгэх итгэл, үнэлэмж, хувийн нууцтай байх эрхийг хүндэтгэнэ. Хохирогчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр түүнтэй холбоотой мэдээллийг задруулхыг хориглоно.

3.3. Хохирогчийн зөвшөөрөл, оролцоог хангана: Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх бүх үйл явцад хохирогчийн сонголт хийх, шийдвэр гаргах эрхийг хүлээн зөвшөөрнө. Өөртэй нь хамаатай шийдвэр гаргах үйл явцад хохирогчийн оролцоог хангана.

3.4.Ялгаварлан гадуурахгүй байна: Хохирогчид үйлчилгээ үзүүлж буй ажилтнууд хохирогчдыг нас, хүйс, яс үндэс, нийгмийн гарал, боловсрол, шашин шүтлэг, итгэл үнэмшил, үзэл бодол, гэрлэлтийн байдал, эдийн засгийн боломж, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл болон бусад байдлаар ялгаварлан надуурхахгүй байна.

5.Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ

5.3. Түр хамгаалан байр нь хохирогчид юуны өмнө хямралын үеийн болон нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулж, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, 33.1.3, 33.1.4, 33.1.5, 33.1.6-д заасан үйлчилгээг болон түр хамгаалан байрлуулах үйлчилгээний онцлогт тохирсон бусад үйлчилгээг үзүүлнэ. **Хохирогчид үзүүлэх үйлчилгээний төрөл:**

5.3.1. аюулгүй байдлын хамгаалалт;

5.3.2. эмнэлгийн тусламж, үйлчилгээ;

5.3.3. сэтгэл зүйн үйлчилгээ;

5.3.4. нийгмийн халамжийн үйлчилгээ;

5.3.5. хүүхэд хамгааллын үйлчилгээ;

5.3.6. эрх зүйн туслалцаа;

5.4. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.4.1 анхан шатны яаралтай тусламж үйлчилгээнд хамруулах

5.4.2. эрүүл мэндийн үзлэг оношлогоонд хамруулах

5.4.3. шаардлагатай тохиолдолд эмчийн жорын дагуу эм, бэлдмэлээр хангах

5.4.4. хэвтэн эмчлүүлэх тохиолдолд эмнэлгийн байгууллагад холбон зуучилж, эргэх холбоотой ажиллах

5.9. Түр хамгаалах байрны онцлогт тохирсон бусад үйлчилгээнд дараах үйлчилгээнүүд орно:

5.9.1. нийгмийн ажлын үйлчилгээ

5.9.2.боловсролын үйлчилгээ

5.9.3.дэмжих бүлгийн үйлчилгээ

5.9.4.асран халамжлах үйлчилгээ

5.9.5. хоол, хүнс, ариун цэвэр гэх мэт анхан шатны суурь хэрэгцээг хангах үйлчилгээ

“Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эмнэлгийн болон сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх” журам. Эрүүл мэндийн сайдын 2017 оны 10сарын12-ны өдрийн А/394 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу ажиллаж байна.

1.1 Энэхүү журмаар гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эмнэлгийн тусламж,үйлчилгээ, сэтгэлзүй, сэтгэл засал, нийгмийн ажлын тусламж үйлчилгээ үзүүлэх

1.2 Хүчирхийлэлд өртсөн хохирогч, өртөх эрсдэл бүхий хүүхдийг илрүүлэх, сэтгэл зүй болон нийгмийн ажлын тусламж , үйлчилгээ үзүүлэхэд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хувь хүний нууцлалын тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Гэмт хэргийн тухай хуульд нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журам, стандарт, заавартай уялдуулан энэхүү журмыг мөрдөн хэрэгжүүлнэ.

Гэрч, хохирогчийг хамгаалах Түр хамгаалах байр нь Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/116 дугаар тушаалаар батлагдсан "Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх" журмын дагуу үйлчилгээ үзүүлдэг.

2017 – 2020 оны 10 дугаар сарын байдлаар 52 иргэн үйлчилгээ авсан.

Иймд гэрч хохирогчийг Түр хамгаалах байрыг тохижуулах , халдваргүйжүүлэх хэрэгцээ шаардлага байна.

2. ТӨСЛИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
1	Төсөл бичих	11 сар	Түр хамгаалах байрны нийгмийн ажилтан Х.Сумъяа
2	Төслийн санхүүжилтээ хүлээн авах	12 сард	Түр хамгаалах байрны нийгмийн ажилтан Х.Сумъяа
3	Түр хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэх	Тогтмол	Түр хамгаалах байрны нийгмийн ажилтан Х.Сумъяа


3. ТӨСВИЙН ЗАРЦУУЛАХ ЗАДАРГАА

№	Материалын нэр	Үндсэн хэмжээ	Хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
Хамгаалах байрыг тохижуулах бараа материал					
1	Босоо толь	Ш	1	100.000	100.000
2	Угаалгын өрөөний толь	ш	1	50.000	50.000
3	Автомат хивс угаагч	Ш	1	300.000	300.000
4	Агаар цэвэршүүлэгч	Ш	1	100.000	100.000
5	Номын тавиур	Ш	1	200.000	200.000
6	Гутлын тавиур	Ш	1	85.000	85.000
7	Бага насны хүүхдийг хооллох ширээ	Ш	1	105.000	105.000
8	Махны машин	ш	1	85.000	85.000
9	Хоолны ширээ сандал	Ш	1	300.000	300.000
10	Хайруулын таваг	ш	1	50.000	50.000
11	Индүүны тавцан	ш	1	40.000	40.000
12	Сурагчийн хичээлийн ширээ сандал	ш	2	100.000	100.000
13	Урт залгуур	ш	1	20.000	20.000
Нийт					1.535.000
Хохирогч хүүхдэд үзүүлэх боловсролын үйлчилгээнд шаардагдах бараа материал					
1	Баримлын шавар	Ш	10	3.000	15.000
2	Сургалтын дэвтэр /хүүхдийн/	ш	20	2450	49.000
3	Тосон бол	ш	20	392	7840
4	Хайч	ш	5	1470	7350
5	Усан будаг	Ш	5	5.000	25.000
6	Өнгийн харандаа /12 өнгийн/	Ш	10	2.450	24.500
7	Зургийн дэвтэр /12 хуудастай/	Ш	20	2000	40.000
8	Өнгийн цаас А4	ш	5	4900	24.500
9	Цаасны цавуу	ш	5	1960	9.800
Нийт					202.990
Дулаан хувцас хэрэгсэл					
1	Бага насны эмэгтэй хүүхдийн дотуур өмд	ш	20	3500	70.000
2	Бага насны эрэгтэй хүүхдийн дотуур өмд	ш	20	3500	70.000

3	Эрэгтэй хүүхдийн оймс	ш	20	2000	40.000
4	Эмэгтэй хүүхдийн оймс	ш	20	2000	40.000
5	Эрэгтэй хүүхдийн фудволк	ш	15	7000	105.000
6	Эмэгтэй хүүхдийн фудволк	ш	15	7000	105.000
7	Эмэгтэй хүүхдийн ноосон өмд	ш	15	10000	150.000
8	Эрэгтэй хүүхдийн ноосон өмд	ш	15	10000	150.000
9	Эмэгтэй хүүхдийн цамц	ш	15	15.000	300.000
10	Эрэгтэй хүүхдийн цамц	ш	15	15.000	300.000
11	Эмэгтэй хүүхдийн куртик	ш	5	50.000	250.000
12	Эрэгтэй хүүхдийн куртик	ш	5	50.000	250.000
13	Эмэгтэй хүүхдийн өвлийн гутал	ш	5	50.000	250.000
14	Эрэгтэй хүүхдийн өвлийн гутал	ш	5	50.000	250.000
	Өвлийн тавчик /18-35 size/	ш	5	10.000	50.000
	Өвлийн тавчик /36-40 size/	ш	5	10.000	50.000
Нийт					2.430.000

НИЙТ: 3,482,990

4. ХАСРАЛТ




Босоо толь




Гутлын тавиур




Хүүхдийн хоолны ширээ



Номын тавиур



Индүүний тавцан



Угаалгын өрөөний толь




Хоолны ширээ сандал




Хивс угаагч



Хайруулын таваг




Махны машин



Агаар цэвэршүүлэгч



Сурагчийн хичээлийн ширээ сандал



Залгуур